

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Сангийн яамнаас боловсруулсан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

1.Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

2.Практикт хэрэгжих боломж:

Энэхүү хуулийн төсөл нь одоо хэрэгжиж байгаа Татварын ерөнхий хуулийг тодорхой хэрэгцээ шаардлагын үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл бөгөөд төсөлд шинээр орсон зохицуулалт 63¹, 76¹ болон 77¹ дугаар зүйлийг хэрэгжүүлэх боломжийн талаар хуулийн этгээдийн хандах хандлагыг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

3.Ойлгомжтой байдал:

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

4.Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлага хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд /иргэн, хуулийн этгээд/ хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно. Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Төслийн 63 ¹ , 76 ¹ болон 77 ¹ зүйлүүдэд заасан зохицуулалт хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэх	Хуулийн төсөл дээр , хуулийн этгээд, Татварын ерөнхий хуулийг хэрэглэх этгээдүүдтэй нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.

3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөлд зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа зэрэг болно.	Хуулийн төсөлд зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан байдлыг шалгах.

ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН БАЙДАЛ

1.Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл:

1. Татвар төлөгчид татварын зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;
2. Татварын өр төлөх хугацаа сунгах боломжийг олгох,
3. Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин,
4. Хуулийг нэг мөр ойлгох зарчмын хүрээнд хоёрдмол утга бүхий зохицуулалтыг засах замаар хуулийн хийдлийг арилган, хэрэгжүүлэхэд энгийн хялбар, харилцан ил тод болгох үндсэн зорилготой байна.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Зорилт-1.Татвар төлөгчид татварын зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх:

1. Энэ зорилтын хүрээнд хуулийн төслийн 77¹ дүгээр зүйлээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Татварын ерөнхий хуулийн 75.1.1-д заасан татварын албаны чиг үүрэг болох зөвлөн туслах үйлчилгээг нарийвчлан тодорхойлж, татвар төлөгчид зөвлөн туслах үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр шинээр бүртгэгдсэн татвар төлөгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, татварын нийтлэг эрсдэлийн мэдээллийг агуулсан гарын авлага, заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлэх, танхимын болон цахим хэлбэрийн сургалтад хамруулах, татварын хууль тогтоомж, татварын тайлангийн маягтад өөрчлөлт орсон тохиолдолд төрийн мэдээлэл эмхэтгэл хэвлэгдсэн, эсхүл улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэнээс хойш ажлын 15 хоногийн дотор тухайн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлуудын мэдээллийг нийт татвар төлөгчдөд татварын бүртгэл, мэдээллийн цахим системээр дамжуулан хүргүүлэх, сургалт зохион байгуулах, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжийн талаар татвар төлөгчид мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор хиймэл оюун ухаан болон их өгөгдөлд

суурилсан, 24 цагийн турш тасралтгүй ажиллах автомат хариулагчийг ажиллуулах зэрэг үйл ажиллагааг татвар төлөгчид үзүүлнэ.

Зорилт-2. Татварын өр төлөх хугацааг сунгах боломжийг болгох:

Хуулийн төслийн 63¹ дэх зүйлээр сүүлийн хоёр татварын жилд албан татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварын өр төлөх хугацааг тухайн татвар төлөгчөөс бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтэд үндэслэн гурван сар хүртэлх хугацаагаар сунгаж болох бөгөөд өр төлөх хуваарийг харьяалах татварын албатай урьдчилан тохирох, татвар төлөгч хяналт шалгалтаар тодорхойлогдсон татварын өрийг хүлээн зөвшөөрч, маргаагүй тохиолдолд түүний бичгээр, эсхүл цахимаар гаргасан хүсэлтэд үндэслэн татварын өрийг 12 хүртэл сарын хугацаанд татварын албатай урьдчилан тохирсон хуваарийн дагуу төлөх зэрэг зохицуулалтыг тусгасан. Ингэснээр татвар төлөгчдийн үйл ажиллагааг дэмжих, өр төлөх хугацааг татвар төлөгчийн гаргасан хүсэлтэд үндэслэн татварын албатай тохирсон хугацаагаар төлөх боломжийг бий болгоно үзсэн.

Зорилт-3. Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин:

Энэ зорилтын хүрээнд хуулийн төслийн 76¹ дэх зүйлээр хууль даган мөрдөлтийн түвшин нь зуу хүртэлх тоон утгаар хэмжигдэх бөгөөд тоон утгад харгалзан маш сайн, сайн, дунд, муу гэж ангилах, хууль даган мөрдөлтийн түвшнийг тооцох шалгуур үзүүлэлтийг энэ хуулийн 35.11-д заасан журмын дагуу шинэчилж, татвар төлөгчид мэдээлэх, татварын алба нь татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг сар, улирал, жилээр тодорхойлж, татвар төлөгчид цахим татварын системээр мэдэгдэх, 76^{1.5}. Энэ хуулийн 76^{1.2}-т заасан хууль даган мөрдөлтийн түвшнийг нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг хойшлуулах, гааль, татварын албаны зөвлөн туслах үйлчилгээг хэрэгжүүлэхэд ашиглах зэрэг зохицуулалтыг тусгасан. Ингэснээр Аж ахуйн нэгжүүдийн хууль даган мөрдөлтийн түвшин, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан дотоод болон импортын НӨАТ-ын төлбөрийг хоёр сар хүртэл хугацаагаар хойшлуулах боломжийг бүрдүүлж, аж ахуйн нэгжийн мөнгөн урсгал, уян хатан байдлыг дэмжих, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, урамшуулах, татвар төлөгчийг татварын эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор гааль, татварын алба татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг тодорхойлж, түвшин буурах нөхцөл бүрдсэн, татварын эрсдэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд энэ талаар татвар төлөгчид мэдэгдэж, татварын тайлан, ногдлоо засах, зөрчлөө арилган татварын эрсдэлээс сэргийлэх боломжийг олгож, хууль даган мөрдөлтийн түвшин сайн албан татвар төлөгчийн НӨАТ төлөх хугацааг хойшлуулах боломжийг бүрдүүлнэ.

Зорилт-4. Хуулийг нэг мөр ойлгох зарчмын хүрээнд хоёрдмол утга бүхий зохицуулалтыг засах замаар хуулийн хийдлийг арилган, хэрэгжүүлэхэд энгийн хялбар, харилцан ил тод болгох үндсэн зорилготой байна.

Хуулийн төслийн 77¹ дүгээр зүйлээр татвар төлөгчид татварын зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, 76¹ дүгээр зүйлээр татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин, 63¹ дүгээр зүйлээр татварын өр төлөх хугацааг сунгах харилцааг нэг мөр зохицуулснаар хуулийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах боломж бүрдэнэ.

1. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Хуулийн төслийн 77¹, 76¹, 63¹ дүгээр зүйлд заасан зохицуулалтуудыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг тодруулахыг зорилоо.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 38 дугаар зүйлд заасны дагуу татварын шинэчлэлийг улс орон даяар бүх нийтийг хамарсан өргөн хүрээний хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлүүлж, татвар төлөгч, эрдэмтэн судлаач, худалдааны танхим зэрэг бүх талын оролцоог хангуулан нээлттэй санал авах ажлаар эхлүүлж, фокус группийн судалгааг хийсэн. Өнгөрсөн хугацаанд Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар, Эдийн засгийн хөгжлийн зөвлөлтэй хамтран улс орон даяар, давхардсан тоогоор 13,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээн авсан.

Үүнээс ирүүлсэн саналуудыг агуулгаар нь судлан үзэхэд нийт саналуудын 56 хувь нь татварын хувь хэмжээтэй холбоотой, 27 хувь нь татварын хууль тогтоомжийн ойлгомжгүй байдлыг бууруулах, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой, үлдсэн 17 хувь нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой саналуудыг ирүүлсэн байв.

Улмаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу татварын хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлал, дагалдах тооцоо, судалгааны хамт 60 хоногийн хугацаанд Сангийн яамны цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулан санал аваад байна. Энэ хүрээнд олон нийтээс Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 26 саналыг ирүүлсэн байна.

Нийт ирүүлсэн саналыг нэг бүрчлэн судалж үзээд 18,464 саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан бол 12,427 саналыг хүлээн авах боломжгүй гэж үзлээ. Мөн үлдсэн 544 санал нь сэтгэгдэл, асуулт хэлбэртэй байлаа. Ирсэн саналын дийлэнх нь татварын хууль тогтоомжийн ойлгомжгүй байдал, татварын байгууллагын үйл ажиллагаа болон байцаагчдын хандлага, хүнд сурталтай холбоотой байв. Энэхүү санал хүсэлтийг нэгтгэн судалж, хуулийн төслийг эцэслэн боловсруулснаар практикт хэрэгжих боломж бүрдэнэ.

2. Ойлгомжтой байдлыг хангасан эсэх:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30, 31 дүгээр зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалд санал авахаар зохих төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагаас санал авах тухай албан бичгийг хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгын хамтаар хавсарган хүргүүлж, санал авсан.

Холбогдох төрийн байгууллагаас ирүүлсэн саналаас үзвэл хуулийн төслийн үзэл баримтлал ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд өгсөн саналыг нэгтгэн судлаад хуулийн төсөлд холбогдох саналыг тусган оруулсан.

Хуулийн төсөл нь татвар төлөгчийн хуульд заасан эрхээ эдлэх боломжийг тодорхойлон өргөжүүлж, татварын албаны зөвлөн туслах үйл ажиллагааг тодотгон зохицуулах эрх зүйн зохицуулалтыг агуулсан. Энэхүү зохицуулалтууд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэрт нийцсэнээс гадна 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг бүрэн хангасан байна гэж үзлээ. Тодруулбал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь утга, агуулгын алдаагүй, ердийн ухамсрын түвшинд ойлгогдох, хэрэгжүүлэхэд хүндрэлгүй байдлаар боловсруулагдсан байна.

3. Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангасан эсэх

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

Хуулийн төсөл нь өмнөх хуулийн хэрэгжилтэд уялдуулан татварын алба, татвар төлөгчийн эрх, үүргийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэгдэн боловсруулагдсан байх ба татварын албаны чиг үүргийг нэмэгдүүлсэн байна.

Харин тус хуулийн төсөлд иргэн болон хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар үүрэг бий болгосон зохицуулалт тусгагдаагүй ба зохицуулалтууд нь бүхэлдээ татварын албаны зөвлөн туслах чиг үүргийг тодотгон, нэмэгдүүлж, практикт хэрэгжүүлсэн байдалтай нийцүүлсэн тул хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг хангасан гэж үзлээ.

4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д дурдагдсан нийтлэг шаардлагуудаас харилцан уялдаатай холбогдох 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т заасан нийтлэг шаардлагууд болон Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шалгах хэрэгслийн дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх:	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.

2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх.	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх,	Энэхүү хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулиудтай давхардаагүй.

- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх:	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх.	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	-
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх.	Тийм	Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд байх бүхий л зохицуулалтыг тусгасан гэж ойлгож байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх.	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Үгүй	-
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Тогтоогоогүй
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.

	хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх,		
12	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Үгүй	Тусгаагүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм	-
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	-	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалт тусгагдаагүй

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Үнэлэлт, дүгнэлт:

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн хүрээнд хийв. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь татварын хуулийн хэрэгжилтийг сайжруулах, татвар төлөгчийн эрхийг хамгаалах, төрийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох зорилгоор татварын алба татвар төлөгчдөд зөвлөн туслах, маргаан таслах зөвлөлийн хараат бус байдлыг хангах, хууль даган мөрдөлтийн түвшнийг тогтоох, эрсдэлийг бууруулах механизм нэвтрүүлэх зэрэг бодлогын шинэчлэлийг тусган боловсруулжээ.

Зөвлөмж:

Татварын ерөнхий хуульд оруулж буй нэмэлт, өөрчлөлтийн төслийн үр нөлөөг үнэлэхэд татварын хууль эрх зүй, санхүү, төсвийн бодлого, төрийн захиргааны чиглэлээр мэргэшсэн судлаач, эрдэмтдийн санал, дүгнэлт нь хуулийн хэрэгжилт, зохицуулалтын үр нөлөөг сайжруулахад чухал ач холбогдолтой болохыг онцолж байна.